

## ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Монгол Улсын Ерөнхий аудиторын  
баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн  
дагуу хийсэн аудитын тайлан

### 2018 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ /САГ-2018/02-СА/



**Төлөвлөлт хангалтгүйгээс ТЭЗ-ийн 2018 оны төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилт зорилтот түвшиндээ хүрээгүй байна**

Чойбалсан хот  
2018 он

## Агуулга

Тайланг бэлтгэсэн:  
Дорнод аймаг дахь Төрийн  
аудитын газрын  
Санхүүгийн аудитын алба

Дарга бөгөөд Тэргүүлэх  
аудитор Б.Болортуул  
Утас: 70584203

Хэлтсийн дарга бөгөөд  
аудитын менежер  
В.Цэнгэлмаа  
Утас: 70584204

Ахлах аудитор  
Д.Нармандах,  
Ж.Баяртуул  
Утас: 70584207

Аудитор  
С.Энхбаатар  
Утас: 70584207

2018 оны 11 дүгээр сар

Аудитын тайлантай  
холбоотой асуудлаар  
нэмж тодруулах, асууж  
лавлах зүйл байвал  
70584207, 70584204  
дугаарын утас болон  
[dornod@audit.gov.mn](mailto:dornod@audit.gov.mn)  
цахим хаягаар  
харилцана уу.

Хаяг: Дорнод аймаг,  
Хэрлэн сум, 7-р баг,  
аймгийн ЗДТГ-ын 2-р байр,  
2 давхар 04 тоот

### **Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй I Бүлэг. Аймгийн 2018 оны төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөөгүй байна.**

1.1. Аймгийн 2018 оны төсвийн суурь зарлага нь Сангийн Яамны баталсан жилийн төсвийн хязгаараас хэтэрсэн байна.

1.2. Төсөвт тодотгол хийж, төсвийн орлого, зардлыг төлөвлөхдөө Төсвийн тухай хууль болон холбогдох журмын заалтуудыг зөрчсөн байна.

1.3. Аймгийн 2018 оны төсвийг алдагдалгүй баталсан байна.

### **II Бүлэг. Аймгийн 2018 оны төсвийн орлогын гүйцэтгэл 75 хувьтай байна.**

2.1. Аймгийн төсвийн 2018 оны нийт орлогын төлөвлөгөөг бүрэн хэрэгжинэ гэж тооцох боломжгүй байна.

2.2. ОНӨААТҮГ-уудад татаасаа бууруулах, орлого нэмэгдүүлэх боломж байна.

### **III Бүлэг. Төсвийн төлөвлөлтөөс шалтгаалж, зарцуулалтын үр дүн буурч байна.**

3.1. Төсвийг оновчтой төлөвлөж, хуваарилаагүйгээс хэмнэлт үүссэн байна.

3.2. Төсвийг зарцуулахдаа Төсвийн болон ТБОНӨХБАУХА тухай хуулийн заалтуудыг зөрчсөн байна.

### **IV Бүлэг. ТЕЗ-ийн 2018 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилт зорилтот түвшиндээ хүрээгүй байна.**

4.1. ТЕЗ-ийн төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний чанарын болон тоон үзүүлэлтийг, хууль, журамд заасны дагуу төсөв захирагч бүрээр тодорхойлоогүй байна.

4.2. ТЕЗ-ийн 2018 оны батлагдсан хөтөлбөр арга хэмжээний биелэлт хангалтгүй байна.

4.3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналтын ажлын үр нөлөө хангалтгүй байна.

## **ДҮГНЭЛТ**

## **ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ИРҮҮЛСЭН ХАРИУ**

## **ЗӨВЛӨМЖ**

## **ТУШААЛ**

## **ТӨЛБӨРИЙН АКТ**

## **АЛБАН ШААРДЛАГА**

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

<b>УИХ</b>	Улсын Их Хурал
<b>ГА</b>	Гүйцэтгэлийн аудит
<b>АДБОУС</b>	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
<b>ҮАГ</b>	Үндэсний аудитын газар
<b>ИТХ</b>	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
<b>МУ</b>	Монгол Улс
<b>ЗГ</b>	Засгийн газар
<b>САГ</b>	Санхүүгийн аудитын газар
<b>ТЕЗ</b>	Төсвийн ерөнхийлөн захирагч
<b>АЗДТГ</b>	Аймгийн Засаг даргын Тамгын газар
<b>ЗДТГ</b>	Засаг даргын Тамгын газар
<b>ГХБХБГ</b>	Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газар
<b>СС</b>	Сангийн Сайд
<b>МХГ</b>	Мэргэжлийн хяналтын газар
<b>ТАХ</b>	Төсөл, арга хэмжээ
<b>ТБОНӨХБАҮХАТХ</b>	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
<b>БОАЖЯ</b>	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
<b>ГИХШХГ</b>	Гадаадын иргэн харьяатын шилжилт хөдөлгөөний газар
<b>ДБЭХС</b>	Дорнод бүсийн эрчим хүчний систем
<b>ОНӨААТҮГ</b>	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
<b>НАА</b>	Нийтийн аж ахуйн
<b>ТӨХК</b>	Төрийн өмчит хувьцаат компани
<b>ОНХС</b>	Орон нутгийн хөгжлийн сан
<b>ЗХУ</b>	Зөвлөлт холбоот улс
<b>БНМАУ</b>	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
<b>НДШ</b>	Нийгмийн даатгалын шимтгэл

## **Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй**

### **Аудит хийх үндэслэл, бүрэн эрх**

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15.2-т заасны дагуу Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

### **Аудитын зорилт:**

Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын сан болон Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулиудын хэрэгжилтийн явцыг шалгаж, дүгнэлт гарган холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- 2018 оны төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөсөн эсэх
- 2018 оны төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх
- 2018 оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулж буй эсэх
- ТЕЗ-ын хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, зорилтот түвшинд нийцсэн эсэх

### **Аудитын хамрах хүрээ:**

Аудитыг ТЕЗ-ийн 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан тэнцэл, судалгаа, мэдээлэл болон бусад холбогдох баримт материалд тулгуурлан гүйцэтгэлээ.

### **Үндсэн мэдээлэл:**

Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 06 дугаар хуралдааны 10 дугаар тогтоолоор аймгийн 2018 оны төсвийг баталсан байна. Үүнд:

1. Дорнод аймгийн 2018 оны төсвийг анх 60,3 тэрбум төгрөгөөр баталсан бол ИТХ-ын 2018 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 7 дугаар хуралдаанаар төсөвт тодотгол хийн 4,7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, орлого, зардлыг 65,0 тэрбум төгрөг болгон баталсан байна.
2. Сангийн Яам нь аймгийн 2017 оны 7 дугаар сарын 08-ны өдөр 2018 оны төсвийн жилийн нийт суурь орлогын хязгаарыг 14,4 тэрбум, суурь зарлагын хязгаарыг 16,2 тэрбум төгрөгөөр батлан ирүүлсэн байна.
3. Аймгийн 2018 оны тодотгосон төсөвт төсвийн суурь зарлагыг 25,7 тэрбум төгрөгөөр баталсан нь хязгаараас нийт 9,5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 7 дугаар хуралдааны 13 дугаар тогтоолоор аймгийн 2018 оны төсвийн орлогыг 315,8 сая төгрөгөөр, ТЕЗ-ын харьяаны төсвийн байгууллагуудын өөрийн орлогыг 118,0 сая төгрөгөөр, төсвийн зарлагыг 1637,5 сая төгрөгөөр, сумдын Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 35,9 сая төгрөгөөр, 2017 оны харилцах дансны үлдэгдлээс зарцуулах мөнгөн дүнг 1321,6 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн шинэчлэн баталсан байна.

Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/198 дугаар тушаалаар аймгийн нийгмийн даатгалын сангийн 2018 оны орлогыг 18577743.0 сая, зарлагыг 48443260,2 сая төгрөгөөр баталсан байна.

#### **Аудитын арга зүй:**

Аудитыг гүйцэтгэхдээ Гүйцэтгэлийн аудитын стандарт (АДБОУС 3000-3100), гарын авлага, журам, удирдамжид заасны дагуу холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, тайлбар, тодруулга, санал асуулга авах, шалгагдагч байгууллагаас авсан судалгаа, мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, тулган баталгаажуулах, анхны баримтаас хөөн шалгах, давтан гүйцэтгэх, ажиглалт хийх, түүвэрчлэн шалгах зэрэг аудитын горимуудыг ашиглав.

#### **Аудитын шалгуур үзүүлэлт:**

Дараах хууль тогтоомж, эрх зүйн актуудыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглана.

##### ➤ Хуулиуд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын багц хуулиуд
- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль
- Татварын багц хуулиуд болон бусад холбогдох хууль тогтоомж, журам заавар

#### **Аудит хийх багийн бүрэлдэхүүн:**

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер В.Цэнгэлмаа хэрэгжүүлж, санхүүгийн аудитын албаны ахлах аудитор Д.Нармандах, Ж.Баяртуул, аудитор С.Энхбаатар нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

#### **Аудитын хугацаа:**

Аудитын талбарын ажлыг 08 дугаар сарын 31-ний өдрөөс эхлүүлэн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ҮАГ-ын Санхүүгийн аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд 11 дүгээр сарын 05-нд хүргүүллээ.

#### **Аудитын тайлангийн бүтэц түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам**

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох газрын санал, түүнд өгсөн тайлбар гэсэн хэсгүүдээс бүрдэх бөгөөд аудитын дэд зорилтын дагуу бичлээ. Аудитын тайлангийн төслийг шалгагдагч байгууллагын удирдлагад танилцуулж санал авсан бөгөөд тайлангийн эцсийн хувилбарыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажууллаа.

I Бүлэг. Аймгийн 2018 оны төвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөөгүй байна.

1.1. Аймгийн 2018 оны төсвийн суурь зарлага нь Сангийн Яамны баталсан жилийн төсвийн хязгаараас хэтэрсэн байна.

Төсвийн тухай хуулийн 8.3.1-д төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан тухайн жилийн орон нутгийн төсвийн хязгаарын саналаа жил бүрийн 6 дугаар сард Сангийн Яаманд хүргүүлэхээр хуульчилсан боловч төсвийн ерөнхийлөн захирагч нь дээрх хуулийн заалтын дагуу санал хүргүүлээгүй байна.

Сангийн Яам нь 2017 оны 7 дугаар сарын 08-ны өдөр аймгийн 2018 оны төсвийн жилийн нийт суурь орлогын хязгаарыг 14,4 тэрбум, суурь зарлагын хязгаарыг 16,2 тэрбум төгрөгөөр тусган ирүүлсэн байна. Төсвийн тухай хуулийн 4.1.8-д жилийн төсвийн хязгаарыг тухайн жилийн төсөв боловсруулахад баримтлах орлогын доод, зарлагын дээд хэмжээг гэж тодорхойлсон. Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хязгаарт багтаан тухайн жилийн төсвийн төслийг боловсруулан ИТХ-аар батлуулахаар Төсвийн тухай хуулийн 31.1.3-т заасан.

1. Аймгийн ИТХ-аар 2018 оны батлагдсан төсөв дэх суурь орлогыг Сангийн Яамны баталсан хязгаартай харьцуулахад дараах байдалтай байна.

*Батлагдсан төсвийн орлого, төсвийн хязгаарын харьцуулалт*

Хүснэгт 1.

/мян.төгрөг/

Орлогын нэр төрөл	хязгаар	ТЕЗ-ын санал	Зөрүү	Хянасан	Зөрүү	Тодотгол	Зөрүү
	1	2	3=1-2	4	5=1-4	6	7=6-1
орон нутгийн орлого	14373558,00	14591080,00	(217522,00)	16049053,00	(1675495,00)	18393599,30	4020041,30
Татварын орлого	13890158,00	14107680,00	(217522,00)	15504053,00	(1613895,00)	16901631,30	3011473,30
Хувь хүний орлогын албан татвар	10120000,00	10120000,00		10956956,10	(836956,10)	10972556,00	852556,00
Цалин хөлс	8700000,00	8700000,00	-	9306956,10	(606956,10)	9806956,00	1106956,00
үйл ажиллагааны орлого	420000,00	420000,00	-	450000,00	(30000,00)	450000,00	30000,00
Хөрөнгийн орлого				500000,00	(500000,00)	410000,00	(90000,00)
Шууд бус орлого	1000000,00	1000000,00	-	700000,00	300000,00	715600,00	(284400,00)
ХХОАТ-ын буцаалт	(910000,00)	(910000,00)	-	(910000,00)	-	(910000,00)	-
ХХОАТ-ын буцаалт	(910000,00)	(910000,00)	-	(910000,00)	-	(910000,00)	-
Хөрөнгийн албан татвар	840390,20	886180,00	(45789,80)	862000,00	(21609,80)	987600,00	147209,80
Үл хөдлөх хөрөнгө	500000,00	500000,00	-	520000,00	(20000,00)	600000,00	100000,00
Бууны албан татвар	42000,00	42000,00	-	42000,00	-	41500,00	(500,00)
Авто тээврийн албан татвар	298390,20	344180,00	(45789,80)	300000,00	(1609,80)	346100,00	47709,80
Бусад татвар төлбөр хураамж	786500,00	786500,00	-	820000,00	(33500,00)	1868346,40	1081846,40
Улсын тэмдэгтийн татвар	530000,00	530000,00	-	540000,00	(10000,00)	1539199,00	1009199,00
Түгээмэл тархацтай ашигт малтмал	2500,00	2500,00	-	20000,00	(17500,00)	68000,00	65500,00
Хог хаягдлын үйлчилгээ	254000,00	254000,00	-	260000,00	(6000,00)	261147,40	7147,40
Газрын төлбөр	238267,80	410000,00	(171732,20)	468267,80	(230000,00)	697108,80	458,841,00
Газрын төлбөр	238267,80	410000,00	(171732,20)	238267,80	-	410000,00	171732,20
Газрын дуудлага худалдаа				230000,00	(230000,00)	287108,80	287108,80
Байгалийн нөөц ашигласны татвар	2810000,00	2810000,00	-	3300829,10	(490829,10)	3277019,10	467019,10
Ойн сангийн нөөц	35000,00	35000,00	-	35000,00	-	35000,00	-

Ан амьтан	-	-	-	7289,10	(7289,10)	7289,10	7289,10
Ус рашааны нөөц	2700000,00	2700000,00	-	3183540,00	(483540,00)	3234730,00	534730,00
Ургамал ашигласны төлбөр	75000,00	75000,00	-	75000,00	-	-	(75000,00)
Бусад татвар төлбөр хураамж	5000,00	5000,00	-	6000,00	(1000,00)	500,00	(4500,00)
Бусад	5000,00	5000,00	-	6000,00	(1000,00)	500,00	(4500,00)
Татварын бус орлого	483400,00	483400,00	-	545000,00	(61600,00)	619200,00	135800,00
Торгуулийн орлого	460000,00	460000,00	-	500000,00	(40000,00)	619200,00	159200,00
Бусад орлого	23400,00	23400,00	-	45000,00	(21600,00)		(23400,00)

Төсвийн тухай хуулийн 8.3.4-т ТЕЗ нь төсвийн төслийн саналаа 8 дугаар сарын 15-ны дотор Сангийн Яаманд хүргүүлэхээр заасан. Уг заалтын дагуу хүргүүлсэн төсвийн саналд суурь орлогыг хязгаараас 217,5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 14,6 тэрбум төгрөгөөр тусгасныг Сангийн Яам хязгаараас 1,7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 16,0 тэрбум төгрөг болгон хянасан байна.

“Аймгийн 2018 оны тодотгосон төсөвт төсвийн суурь орлогыг Сангийн Яамнаас баталсан доод хязгаараас нийт 4,0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 18,4 тэрбум төгрөгөөр баталсан байна. Харин байгалийн ургамал ашигласны төлбөрийн 75,0 сая төгрөгийн орлогыг хасаж төлөвлөсөн нь БОАЖЯ-ны Сайдын 2017 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн А/275 тоот “Байгалийн ургамлыг 5 жил ашиглахгүй байх тухай” тушаал гарсантай холбоотой байна.

2. Төсвийн тухай хуулийн 58.2-т аймаг өөрийн төсвөөр хэрэгжүүлэх, тухайн шатанд хамаарах чиг үүргүүдийг тусгасан бөгөөд эдгээр чиг үүргүүдээс 58.2.1 дэх “аймгийн удирдлагыг хэрэгжүүлэх”, 58.2.4 дэх “нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах”, 58.2.13 дахь “байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх” гэсэн чиг үүргүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотой урсгал болон хөрөнгийн зардлын нийлбэрээр төсвийн суурь зарлагыг тооцохоор заажээ.

Орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой зардал нь аймгийн ИТХ, ЗДТГ, сумдын ИТХ, ЗДТГ, баг болон Засаг даргын шууд харьяанд байгаа орон нутгийн төсөвт байгууллагуудын урсгал болон хөрөнгийн зардлын нийлбэрээр тодорхойлогддог.

Аймгийн 2017 оны батлагдсан төсөв дэх суурь зарлагыг Сангийн Яамны баталсан хязгаартай харьцуулахад дараах байдалтай байна.

#### Батлагдсан төсвийн зарлага, төсвийн хязгаарын харьцуулалт

Нийт зарлага	Сангийн яамны тогтоосон хязгаар	ТЕЗ-ийн төсвийн санал	Зөрүү	Сангийн яамны хянасан дү	Зөрүү	Хүснэгт 2. /мян.төгрөг/ 2018 оны тодотгол хийсэн төсөв	
						2018 оны тодотгол хийсэн төсөв	Зөрүү
	1	2	3=1-3	4	5=1-4	6	7=6-1
Аймгийн ИТХ	196240,3	325964,9	(129724,6)	196117,9	122,4	343817,8	147577,5
Сумын ИТХ	561669,5	960160,1	(398490,6)	595046,5	(33377,0)	697071,3	135401,8
Аймгийн ЗДТГ	1037553,6	1847684,2	(8108130,6)	1276150,6	(238597,0)	1110682,1	73128,5
Сумын ЗДТГ	3796095,1	6314860,7	(2518765,6)	4120971,5	(324876,4)	6514741,3	2718646,2
Санхүүгийн аудитын газар	90846,4	183435,1	(92588,7)	104023,7	(13177,3)	174125,5	83279,1

Орон нутгийн өмчийн газар	98383,8	125122,1	(268738,3)	98278,8	105,0	138447,9	40064,1
Аймгийн халамжийн сан	8137949,0	11137500,0	(2999551,0)	8013654,0	124295,0	8962753,2	824804,2
Ахмадын хороо	46603,8	63380,8	(16776,8)	46603,8	0	46603,8	0
Сум дундын ойн анги	38857,4	98126,2	(59268,8)	32692,0	(6165,4)	40067,0	(1209,6)
Байгаль орчин аялал жуулчлалын газар	293379,7	464383,2	(171003,5)	341910,3	(48530,6)	367141,4	73761,7
Байгаль орчин нөхөн сэргээх хамгаалах зардал	841500,0	1034000,0	(192000,0)	1030510,9	(189010,9)	1062110,9	220610,9
Хотын тээвэр	66000,0	160000,0	(94000,0)	66000,0	0	66000,0	0
Хот тохижуулах	287071,1	1344948,5	(1057877,4)	575329,3	(288254,0)	955440,3	668369,2
Усны татаас	64000,0	100000,0	(36000,0)	64000,0	0	60000,0	(4000,0)
Мал хамгаалах сан	270000,0	350001,0	(80001,0)	270000,0	0	60000,0	(210000,0)
Авто замын сан	285120,0	324000,0	(38880,0)	270000,0	15120,0	311490,0	26370,0
Ахмадын чөлөөт цагийн төв	25726,0	26400,0	(674,0)	25468,7	257,3	26400,0	0
Жолоочийн хариуцлагын даатгал	32000,0	36000,0	(4000,0)	30000,0	2000,0	34610,0	(2610,0)
Нийт	16168995,7	24895966,6	(8726970,9)	17156754,0	(987758,3)	25715054,6	

ТЕЗ-ийн Сангийн Яаманд хүргүүлсэн төсвийн саналд суурь зарлагыг хязгаараас 8,7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 24,9 тэрбум төгрөгөөр тусгасныг, Сангийн Яам хянахдаа 17,2 тэрбум төгрөг болгон бууруулсан байна. Сангийн Яам саналд тусгагдсан зарлагыг бууруулсан ч хянасан дүн нь анх баталсан төсвийн хязгаараас 987,8 сая төгрөгөөр нэмэгдсэн байгаа нь суурь зарлагыг хязгаараас хэтрүүлэхгүй гэсэн заалтыг Сангийн яам болон ТЕЗ нар зөрчсөн байна.

Аймгийн 2018 оны тодотгосон төсөвт төсвийн суурь зарлагыг 25,7 тэрбум төгрөгөөр баталсан нь хязгаараас нийт 9,5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

**1.2. Төсөвт тодотгол хийж, төсвийн орлого, зардлыг төлөвлөхдөө Төсвийн тухай хууль болон холбогдох журмын заалтуудыг зөрчсөн байна.**

### **Орон нутгийн төсвийн тодотгол**

Дорнод аймгийн 2018 оны төсвийг анх 60,3 тэрбум төгрөгөөр баталсан бол ИТХ-ын 2018 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 7 дугаар хуралдаанаар төсөвт тодотгол хийн 4,7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, орлого, зардлыг 65,0 тэрбум төгрөг болгон баталсан байна.

Төсвийн тухай хуулийн 34.2 дахь заалтад засаг даргын тухайн жилийн төсөвт тодотгол боловсруулж ИТХ-д өргөн барих тохиолдлуудыг заасан. Үүнд:

1. Дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй тохиолдол бий болсон.
2. Урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж орон нутгийн төсөвт алдагдалтай болох нөхцөл байдал бий болсон.
3. Инфляцийн хэмжээ 2 дахин болон түүнээс дээш хувиар өссөнөөс шалтгаалан батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт өөрчлөлт



## оруулах болсон.

Тодотгол хийсэн тухайн хугацаанд дээд шатны төсөвт тодотгол хийгдээгүй байгаа бөгөөд инфляцийн түвшин төсөв батлагдах үетэй харьцуулахад 4 орчим хувиар нэмэгдсэн байгаа тул тодотгол хийх 1, 3-р тохиолдол үүсээгүй байна. Төсөв алдагдалтай болсон 2-р тохиолдлын хувьд зардал буурах ёстой бол тодотголоор орлого болон зардлыг 4,7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн нь энэ тохиолдолд хамаарахгүй болохыг харуулж байна.

## Анхны төсөв болон тодотгосон төсвийн орлогын харьцуулалт

Хүснэгт 3.  
/мян.төг/

Орлогын нэр төрөл	2018 оны төсөв	2018 оны төсвийн тодотгол	Зөрүү
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ОРЛОГО</b>	<b>60275049.50</b>	<b>65036341.10</b>	<b>4761291.60</b>
<b>ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО</b>	<b>17221490.60</b>	<b>18393599.30</b>	<b>1172108.70</b>
<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>15846822.60</b>	<b>16901631.30</b>	<b>1054808.70</b>
<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	<b>10062556.10</b>	<b>10062556.10</b>	<b>0.00</b>
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал			
болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	9806956.10	9806956.10	0.00
Үйл ажиллагааны орлого	450000.00	450000.00	0.00
Шууд бус орлого	715600.00	715600.00	0.00
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-910000.00	-910000.00	0.00
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-910000.00	-910000.00	0.00
<b>Хөрөнгийн албан татвар</b>	<b>987600.00</b>	<b>987600.00</b>	<b>0.00</b>
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	600000.00	600000.00	0.00
Бууны албан татвар	415000.00	415000.00	0.00
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	346100.00	346100.00	0.00
<b>Бусад нийтлэг төлбөр, хураамж</b>	<b>874147.40</b>	<b>1876847.30</b>	<b>1002699.90</b>
Улсын тэмдэгийн хураамж	539000.00	1539199.90	1000199.90
Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	66000.00	68000.00	2000.00
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	260647.40	261147.40	500.00
Бусад татвар	8500.00	8500.00	0.00
<b>Газрын төлбөр</b>	<b>645000.00</b>	<b>697108.80</b>	<b>52108.80</b>
Газрын төлбөр	410000.00	410000.00	0.00
Дуудлага худалдаа	235000.00	287108.80	52108.80
<b>Байгалийн нөөц ашигласны төлбөр</b>	<b>3277019.10</b>	<b>3277019.10</b>	<b>0.00</b>
Ойн нөөц ашигласны төлбөр	35000.00	35000.00	0.00
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	7289.10	7289.10	0.00
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	3234730.00	3234730.00	0.00
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	-	-	-
<b>Бусад татвар</b>	<b>500.00</b>	<b>500.00</b>	<b>0.00</b>
Бусад татвар	500.00	500.00	0.00
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,374,668.00</b>	<b>1491968.00</b>	<b>117300.00</b>
<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1334668.00</b>	<b>1431968.00</b>	<b>97300.00</b>
Торгуулийн орлого	517200.00	619200.00	102000.00
Төсөвт байгууллагын өөрийн орлого	150959.00	135959.00	15000.00
Бусад орлого	274109.00	282409.00	8300.00
Хүүгийн орлого	392400.00	394400.00	2000.00
<b>Хөрөнгийн орлого</b>	<b>40000.00</b>	<b>60000.00</b>	<b>20000.00</b>
Өмч хувьчлалын орлого	40000.00	60000.00	20000.00
<b>Тусламжийн орлого</b>	<b>4698847.70</b>	<b>4896704.70</b>	<b>197857.00</b>
Хандив тусламж /дотоод/	559606.00	757463.00	197857.00
Аймгаас авсан санхүүгийн дэмжлэг	4139241.70	4139241.70	0.00
Сумаас авсан санхүүгийн тэгшитгэл	0.00	0.00	0.00
<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	<b>38734777.00</b>	<b>38730191.50</b>	<b>20832.50</b>
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	30467857.30	30488689.80	20832.50
Орлого	3650839.70	3650421.70	0.00
Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	4591080.00	4591080.00	0.00
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>0</b>	<b>3400069.70</b>	<b>3400069.70</b>
<b>Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/</b>		<b>3400069.70</b>	<b>3400069.70</b>

Орлогыг татварын, татварын бус, тусламжийн орлогын бүх төрөл дээр 97,3 сая төгрөгөөс 1,0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

**Анхны төсөв болон тодотгосон төсвийн зардлын харьцуулалт**

Хүснэгт 4.

/мян.төг /

Зарлагын нэр төрөл	2018 оны төсөв	2018 оны төсвийн тодотгол	Зөрүү
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>60275049.50</b>	<b>65036341.10</b>	<b>4761291.60</b>
<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	<b>59369767.30</b>	<b>64121158.90</b>	<b>4751391.60</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>51945876.70</b>	<b>56774181.90</b>	<b>4828305.20</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>39107887.50</b>	<b>39558563.00</b>	<b>450675.50</b>
Цалин хөлс болон нэмэгдэл	23947169.90	24000337.70	53167.80
Ажил олгогчоос НД төлсөн	2829324.10	2844766.00	15441.90
Байр ашиглалттай холбоотой	2063212.40	2039641.90	-23570.50
Хангамж, бараа материал	1130571.80	1119534.90	-11036.90
Норматив зардал	2401351.90	2382787.60	-18564.30
Эд хогшил урсгал зардал	402237.40	412839.90	10602.50
Томилот	160946.50	162429.10	1482.60
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил	860070.10	897273.70	37203.60
Бараа үйлчилгээний бусад зардал	5313003.40	5698952.20	385948.80
<b>ТАТААС</b>	<b>875743.90</b>	<b>875743.90</b>	<b>0.00</b>
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	875743.90	875743.90	0.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>11962245.30</b>	<b>16339875.00</b>	<b>4377629.70</b>
Засгийн газрын урсгал шилжүүлэг	135610.00	4544851.70	4409241.70
Бусад урсгал шилжүүлэг	11826635.30	11795023.30	-31612.00
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>7423890.60</b>	<b>7346977.00</b>	<b>-76913.60</b>
Барилга байгууламж	326490.00	326490.00	0.00
Бусад хөрөнгө	7097400.60	7020487.00	-76913.60
<b>ЭРГЭН ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ДҮН</b>	<b>905282.20</b>	<b>915182.20</b>	<b>9900.00</b>
Эргэн төлөгдөх зээл	905282.20	915182.20	9900.00

Зардлын хувьд хөрөнгийн зардлыг 9,9 сая төгрөгөөр бууруулж, урсгал зардлыг 4,7 тэрбум, эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр дүнг 9,9 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

**Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлт:**

Төсвийн 2018 оны орлогыг төлөвлөхдөө өмнөх оны төлөвлөгөөнөөс татварын орлогыг 1,1 тэрбум төгрөгөөр өсгөн, татварын бус орлогыг 0,1 тэрбум төгрөгөөр бууруулсан байна. Төлөвлөлтийг сүүлийн жилүүдийн дундаж болон өмнөх оны гүйцэтгэлийг харгалзан төлөвлөдөг байна.

Орлогын төлөвлөгөөний өмнөх оны гүйцэтгэлийг судлахад татварын орлого нь 2017 онд 2,5 тэрбум төгрөгөөр давж, татварын бус орлого 1,5 тэрбум төгрөгөөр тасарч, нийт дүнгээрээ 1,0 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

Татварын орлогын хувьд хувь хүний орлогын албан татвар 1,3 тэрбум, нийтлэг төлбөр хураамж 0,5 тэрбум, байгалийн нөөц ашигласны төлбөр 0,5 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэн нь нөлөөлсөн байна. Гүйцэтгэл 2,5 тэрбум төгрөгөөр

давсан байхад төлөвлөлтийг тэр хэмжээнээс 2 дахин багаар нэмэгдүүлсэн нь НДШ-ийн хувь хэмжээ 1 хувиар өссөнөөс шалтгаалсан хувь хүний орлогын албан татварын бууралт, тогтмол бус үйл ажиллагааны орлогоос орох татварыг өмнөх гүйцэтгэлээр төлөвлөх боломжгүй, байгалийн ургамал ашигласны төлбөр энэ онд төвлөрөхгүй, уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдээс орох усны төлбөр багасна гэж тооцоолсон гэсэн тайлбарыг өгсөн. Цалин хөлснөөс суутган тооцох татварын хувьд НДШ-ийн өсөлтөөс шалтгаалж буурах хувь 1,1 байгаа нь төлөвлөсөн дүнг 0,2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байгааг харуулж байна. Усны төлбөрийн хувьд газрын гүний усны ашиглалтыг бууруулах орон нутгийн бодлого шийдвэр, холимог металлын олборлолт явуулдаг “Шинь Шинь” компанийн үйл ажиллагааг байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллөөс шалтгаалан зогсоож болзошгүй нөхцөл байдал үүссэн зэрэг нь төлөвлөлтийг бууруулах шалтгаан болсон байна.

Харин Улсын тэмдэгтийн хураамжийг 2017 оны төлөвлөгөөнөөс 1,0 тэрбум, гүйцэтгэлээс 0,6 тэрбум төгрөгөөр өсгөн төлөвлөсөн нь үндэслэлгүй байна. Учир нь Хэрлэн сум нь Төсвийн тухай хуулийн 23.4.9-д улсын төсөвт төвлөрүүлэхээр заасан гадаадын иргэн, харьяалалгүй хүнд зөвшөөрөл, виз олгохтой холбоотой тэмдэгтийн хураамжийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна.

Татварын бус орлогын хувьд 2017 онд тусламжийн орлогыг 1,7 тэрбумаар төлөвлөсөн нь бүрэн тасарсан. Гэтэл 2018 онд мөн албан ёсны гэрээ хэлцэлгүй 0,7 тэрбум төгрөгөөр тусламжийн орлогыг төлөвлөсөн байна.

Төрийн аудитын газраас “Аймгийн 2018 оны орон нутгийн төсөв”-ийн төсөлд эх үүсвэр тодорхойгүй 1,0 тэрбум төгрөгийн орлого бууруулах тухай саналыг өгсөн ч 0,3 тэрбумаар бууруулж 0,7 тэрбумыг нь хэвээр үлдээн баталсан байна.

### **Аймгийн төсвийн зарлагын төлөвлөлт:**

Төсөв нь Төсвийн тухай хуульд заасан зарчим, шаардлагад нийцсэн байх ёстой. Аймгийн 2018 оны төсөвт дээрх зарчим, шаардлагад нийцээгүй дараах хөтөлбөр, арга хэмжээнүүд байна. Үүнд:

1. Төсвийн тухай хуулийн 6.6.6-д “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх”, 4.1.24 дэх “хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг” хэлнэ гэсэн заалтуудтай нийцэхгүй хөрөнгө оруулалтуудыг төлөвлөсөн байна.

- Хилийн 0132 дугаар ангид хөгжим, техник хэрэгсэл 6,8 сая төгрөг
- ЗХ-ний 0327 дугаар ангид соёл мэдээллийн төвийн багаж тоног төхөөрөмж 20,0 сая төгрөг
- Чойбалсан нисэх онгоцны буудлын зочид хүлээн авах танхимын засварт аймгийн төсвөөс 20,0 сая төгрөг, Хэрлэн сумын төсвөөс 8,0 сая төгрөг
- Аймгийн МХГ-ын хавирга боомт дахь ажилчдын байр 20,0 сая төгрөг
- Статистикийн хэлтсийн автомашин засварт 2,8 сая төгрөг
- Хэрлэн сум зүүн бүс дэх ГИХШХГ-т ажлын байр худалдан авахад 600,0 сая төгрөг

Эдгээр 677,6 сая төгрөгийн 6 ажлаас 657,6 сая төгрөгийн 5 ажлыг төсөвт хийсэн тодотголоор нэмэгдүүлсэн байна.

2. Төсвийн тухай хуулийн 6.5.5-д “хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ач

холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дараалал, арга замыг тодорхойлох шийдвэрт олон нийтийн саналыг харгалзан үзэх”, 60.3.1-д “Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ”, 60.3.6-д “Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ”, Сангийн Сайдын 2014 оны “ОНХС-гийн зарцуулалт”-ын журмын 4.2, 4.3, 4.4 дахь заалтуудтай нийцэхгүй хөтөлбөр, арга хэмжээг ОНХС-аас санхүүжүүлэхээр төлөвлөн баталсан байна.

- Гэр хорооллын айл өрхийн усны алдагдалд олгох санхүүжилт 60.0 сая төгрөг
- Хүний хөгжил, хөгжлийн индексийг дээшлүүлэх хөтөлбөр арга хэмжээнд нийт 232,0 сая төгрөг
- Баян-Уул сумын ЗДТГ нь авто машин засвар 2,8 сая төгрөг
- Баян-Уул сум Улзын хөгжил ОНӨҮГ-ын автомашин засварт 4,5 сая төгрөг
- Баяндун сум ахмадын хорооны үйл ажиллагааны дэмжлэгт 2,0 сая төгрөг
- Чулуунхороот сум гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 4,0 сая төгрөг

Эдгээр 305,3 сая төгрөгийн 6 төрлийн хөтөлбөр, арга хэмжээнээс 37,0 сая төгрөгийн ажлыг тодотголоор нэмэгдүүлсэн байна.

3. Хуулийн 29.4-д “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэсэн заалтыг зөрчин нийт 105,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөн баталсан байна.

- Хэрлэн сумын 11 дүгээр багийн байр /өрхийн эмнэлгийн хамт/-90,0 сая төгрөг тодотголоор нэмэгдсэн/
- Баяндун сумын эмнэлгийн моргийн барилга 15,0 сая төгрөг

4. Батлагдсан төсөв дэх орон тоог аймгийн ИТХ 5, Чойбалсан, Матад сумын ИТХ 2, аймгийн ЗДТГ 14, сумдын ЗДТГ 6, Санхүү хяналт аудитын газар 5, Орон нутгийн өмчийн газар 3-аар буюу нийт 35-аар илүү төлөвлөж цалингийн зардлыг 361,6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Дээрх 361,6 сая төгрөгийн цалингийн зардлаас 5,0 сая төгрөгийн зардлыг төсвийн тодотголоор нэмэгдүүлсэн байна.

Төрийн аудитын газраас төсвийн төсөлд Төсвийн тухай хуульд заасан зарчим, шаардлагад нийцэхгүй 1,1 тэрбум төгрөгийн зардлыг бууруулах санал өгсний 446,4 сая төгрөгийн саналыг хүлээн авч тусгасан байна.

### **1.3. Аймгийн 2018 оны төсвийг алдагдалгүй баталсан байна.**

Сангийн Яам нэгтгэсэн тайлангаар санхүүгийн дэмжлэгт 4591080,0 мянган төгрөгийг санхүүжүүлж, төсөв алдагдалгүйгээр баталсан байна. Гэвч тусламжийн орлогын 757,5 сая төгрөг, улсын тэмдэгтийн хураамжийн 1,0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг тооцоо, судалгаагүйгээр нэмэгдүүлэн төлөвлөсөн нь гүйцэтгэлээр 1,4 тэрбум төгрөгөөр тасрах магадлалтай байгаа нь тухайн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн ажлын гүйцэтгэлээр өр үүсэж болзошгүй байна.

**II Бүлэг. Аймгийн 2018 оны төсвийн орлогын гүйцэтгэл 75 хувьтай байна.**

**2.1. Аймгийн төсвийн 2018 оны нийт орлогын төлөвлөгөөг бүрэн хэрэгжинэ гэж тооцох боломжгүй байна.**

Орон нутгийн төсвийн нийт орлогын гүйцэтгэл 2018 оны 9 дүгээр сарын байдлаар 46,3 тэрбум төгрөг байна.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс болон Татварын хэлтэс нь орлогын хүлээгдэж буй гүйцэтгэлийг 2019 оны төсвийг төлөвлөх явцад дараах байдлаар тооцсон байна.

Хүснэгт 5.  
/сая төгрөг/  
ХБГ

Үзүүлэлт	2016 оны гүйцэтгэл	2017 оны гүйцэтгэл	Жилийн төлөвлөгөө	Гүйцэтгэл /9 дүгээр сарын байдлаар/	
НИЙТ ОРЛОГО	53827.5	54690.5	61636.1	46266.8	61725.1
ТАТВАРЫН ОРЛОГО	15508.4	18340.9	17295.9	12439.7	17418.1
Орлогын албан татвар	9045.8	10909.4	10456.9	7669.6	10514.7
Цалин, хөдөлмөрийн хөлс, урамшуулал тэдгээртэй хөдөлмөр орлого	8757.3	10216.0	9806.9	7133.6	9595.9
Урамшуулал болон адилтгах эрхлэлтийн орлого					
Үйл ажиллагааны орлого	252.8	612.8	450.0	304.7	428.0
Хөрөнгийн орлого	0	15.9	394.4	589.2	679.2
Шууд бус орлого	938.4	968.7	715.6	519.1	688.6
ХХОАТ-ын буцаалт	-902.7	-904.0	-910.0	-877.0	-877.0
Хөрөнгийн албан татвар	900.5	954.1	987.6	787.3	954.8
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	507.7	574.4	600.0	417.8	570.0
Бууны албан татвар	37.5	42.2	41.5	22.0	41.9
Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	355.3	337.5	346.1	347.5	342.9
Бусад татвар, төлбөр, хураамж	5562.1	6477.4	5851.4	3982.8	5948.6
Бусад нийтлэг төлбөр, хураамж	682.0	1383.8	1876.8	777.6	1878.1
Улсын тэмдэгийн хураамж	290.5	903.5	1539.2	475.5	1539.2
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	138.9	153.7	68.0	59.5	71.2
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	247.2	267.7	261.1	198.2	261.7
Бусад татвар	5.4	58.9	8.5	44.4	6.0
Газрын төлбөр	1224.4	886.0	697.1	447.2	546.5
Байгалийн нөөц ашигласны төлбөр	3655.7	4207.6	3277.0	2758.0	3524.0
Ойн нөөц ашигласны төлбөр	65.1	67.5	35.0	19.5	40.0
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	43.1	12.8	7.3	12.9	4.0
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	3401.7	3928.3	3234.7	2725.6	3480.0
Байгалийн ургамал ашигласны төлбөр	145.8	199.0	0	0	0.0
Бусад татвар	0	0	0.5	0	0.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	38319.1	36349.6	44340.2	33827.1	44307.0
Торгуулийн орлого	652.6	725.0	619.2	814.0	900.0
Төсөвт байгууллагын өөрийн орлого		0	60.8	53.9	58.9
Түрээсийн орлого	1.0	2.6	0	2.4	2.4

Бусад орлого	363.9	215	282.4	428.6	428.6
Хөрөнгийн орлого		0	60.0	60.3	60.3
Тусламжийн орлого		0	757.5	293.2	293.2
Аймгаас авсан санхүүгийн дэмжлэг	164.3	0	3726.9	3200.6	3730.2
Улсын төсөв, орон нутгийн төсөв хоорондын орлого	37137.3	35407.0	38833.4	28974.1	38833.4

Дээрх хүснэгтээс харахад энэ онд орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлого нийт дүнгээрээ биелнэ гэсэн тооцооллыг хийсэн байгаа бөгөөд нэр төрлөөр нь авч үзвэл хувь хүний орлогын албан татварыг 0,2 тэрбум, хөрөнгийн албан татварыг 32,8 сая төгрөгөөр тасарна, бусад орлогыг уг тасралтыг нөхөхөөр биелнэ гэж тооцоолсон байна.

Хувь хүний орлогын албан татварын гүйцэтгэл 9 дүгээр сарын байдлаар 7,9 тэрбум төгрөг байна. Өмнөх жилийн 4 дүгээр улирлын дундаж орлогын хэмжээ 900,0 сая төгрөг байгаа бөгөөд 4-р улиралд хуулийн дагуу үр дүнгийн урамшуулал олгогддог тул энэ хэмжээ нэмэгддэг. Дунджийг нэмэгдэхгүй гэж тооцсон ч сүүлийн 3 сард 2,7 тэрбум төгрөгийн орлого төвлөрч жилийн төлөвлөгөө бүрэн биелэхээр байна.

Хөрөнгийн албан татвар нь 3 төрлийн татвараас бүрдэж байгаа бөгөөд эдгээрээс үл хөдлөх хөрөнгийн албан татварыг 30,0 сая төгрөг, авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг 3,2 сая төгрөгөөр тасарна гэж тооцсон байна. Уг татваруудаас 9 дүгээр сарын гүйцэтгэлээр тээврийн хэрэгслийн татвар жилийн дүнгээр биелсэн, үл хөдлөх хөрөнгийн татвар 69 хувийн биелэлттэй байна. Үл хөдлөх хөрөнгийн татварыг хуульд тухайн жилийн 12 дугаар сарын 25-ны дотор төлөхөөр заасан байдгаас татвар төлөгчид өмнөх жилүүдийн дунджаар 12 дугаар сард төлдөг бөгөөд татварын суурь буураагүй тул биелэх боломжтой гэж үзэж байна.

Харин улсын тэмдэгтийн хураамжийн орлогод 9 дүгээр сарын байдлаар төлөвлөсөн 1,5 тэрбум төгрөгөөс 0,5 тэрбум төгрөг орсон байна. Үүнээс Хэрлэн сумын төлөвлөсөн 1,0 тэрбум төгрөгийн хураамж нь үндэслэлгүй төлөвлөгдсөн бөгөөд бүрэн биелнэ гэж тооцох боломжгүй байна.

Татварын бус орлогын хувьд тусламжийн орлого нь 757,5 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 293,2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Уг орлогыг 2018 оны 3 сард хийсэн төсвийн тодотголоор газрын тосны хайгуулын зөвшөөрөл бүхий 5 компаниас төвлөрүүлэхээр тооцсон ч албан ёсоор байгуулсан гэрээ хэлэлцээр байхгүй байна. Хандив тусламжийн орлогыг өмнөх онд 1705,9 сая төгрөгөөр төлөвлөсөн нь бүрэн тасарсан бөгөөд 2018 онд ч бүрэн биелнэ гэж тооцох боломжгүй байна.

Бусад орлогын хувьд төлөвлөсөн дүнгээр биелэх боломжтой байна.


## **2.2. ОНӨААТҮГ-уудад татаасаа бууруулах, орлого нэмэгдүүлэх боломж байна.**

Аймгийн 2018 оны төсөв батлах тухай тогтоолоор аймгийн төвийн төсөвт байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөөг 13,0 сая төгрөгөөр, сумдын төсөвт байгууллагуудын төлөвлөгөөг 47,8 сая төгрөгөөр баталсан байна. Орон нутгийн өмчит газрын хувьд орлого төвлөрүүлэхээр төлөвлөгдөөгүй байна.

Төлөвлөгөөний биелэлт 9 дүгээр сарын гүйцэтгэлээр нийт 53,9 сая төгрөг байгаа нь жилийн төлөвлөгөөтэй харьцуулахад 88,6 хувьтай байна. Төсөвт байгууллагуудын орлого өмнөх жилүүдэд нийт дүнгээрээ биелдэг ч сумдын ЗДТГ, Соёлын төвүүдийн орлого жил бүр тасарсан байна. /Графикаар харуулав./

Төсөвт байгууллагуудын өөрийн орлогын 2016-2018 оны  
төлөвлөгөө гүйцэтгэл

График 1.



Аймгийн төсөвт байгууллагын орлогын төлөвлөгөөний биелэлт нь сумдын төлөвлөгөөний тасралтыг нөхөж байгаа бөгөөд АЗДТГ аймгийн төсөвт байгууллагуудын орлогын 67-80 хувийг бүрдүүлж байна. ЗДТГ-ын хувьд хуульд заасан харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн төлөвлөлт, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх, тухайн шатны хурлын хэвийн үйл ажиллагааг хангах зэрэг чиг үүргүүдийг хэрэгжүүлэх байгууллага бөгөөд хуулиар төсөвт орлого төвлөрүүлэх чиг үүрэг хүлээгээгүй тул орлого нэмэгдүүлэх боломжгүй байна.

Аймгийн хэмжээнд нийт 16 орон нутгийн өмчит газар үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс аймгийн төвд 3, сумдад 13 байгууллага байна. Сумдын ОНӨААТҮГ-ын хувьд үйл ажиллагаа нь жигдрээгүй, тогтмол бус шинжтэй, орлогын эх үүсвэр тодорхойгүй байна.

Аймгийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа 3 орон нутгийн өмчит газруудын хувьд орлого төвлөрүүлэх боломжийг судлахад дараах байдалтай байна.

1. “Гэрэл Сэтгэмж” ОНӨААТҮГ нь аймгийн төвийн гудамж талбайн гэрэлтүүлгийн засвар үйлчилгээг хийж орон нутгаас бүрэн санхүүждэг бөгөөд орлого олох үйл ажиллагаа явуулдаггүй байна.
2. “Дорнод НАА” ОНӨААТҮГ нь аймгийн төвд байгаа айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дулаан дамжуулах, цэвэр ус түгээх, бохир ус татан зайлуулах үйлчилгээг үзүүлдэг бөгөөд аймгийн төсвөөс гэр хорооллын айл өрхийн усны борлуулалтын үнийн бууралтаас үүссэн алдагдалд татаас авдаг байна. Тус байгууллагын 2017 онд төвлөрсөн системд холбогдсон айл өрх, аж ахуйн нэгжид борлуулсан усны хэмжээ, түгээх байгууламжаас гарсан усны 55,0 хувь байна. Энэ хувийг 5-аар өсгөж усны алдагдлыг бууруулахад л орлого 75,0 сая

төгрөгөөр нэмэгдэхээр байгаа нь 2018 онд төсвөөс олгохоор төлөвлөсөн 60,0 сая төгрөгийн татаасыг бүрэн нөхөхөөр байна.

3. “Чойбалсан хөгжил” ОНӨААТҮГ нь аймгийн төвд байгаа айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад хог тээвэрлэлтийн үйлчилгээг үзүүлдэг бөгөөд аймгийн төсвөөс бүрэн санхүүжигдэж байна. Тус байгууллага нь санхүүжилтээ аймгаас авч, хог тээвэрлэлтийн үйлчилгээний төлбөрийг Хэрлэн сумд төвлөрүүлж байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.2.2-т заасан “жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх” гэсэн зарчимд нийцэхгүй байна. Хог хаягдлын хураамж нь Төсвийн тухай хуулиар сумын төсвийн орлогын бүрэлдэхүүн тул санхүүжилтийг нь орлогыг хассан дүнгээр Хэрлэн сумаас олгох нь зүйтэй байна. Мөн орлого төвлөрүүлэх талаар хийсэн 3 талт гэрээнд ДБЭХС ТӨХК-д гэр хорооллын өрхөөс авах төлбөрийн 35 хувийг, Дорнод Нийтийн аж ахуй ОНӨААТҮГ-т орон сууцны айл өрхөөс авах төлбөрийн 20 хувийг өгч байгаа нь харилцан адилгүй байна. Уг байгууллагуудад төлж буй шимтгэлийн хувийг хураалтын үйл ажиллагааны бодит зардалд суурилан бууруулбал, тэр хэмжээгээр өөрийн орлогыг нэмэгдүүлж төсвөөс авах санхүүжилтийг бууруулах боломж байна.

**III бүлэг. Төсвийн төлөвлөлтөөс шалтгаалж, зарцуулалтын үр дүн буурч байна.**

**3.1. Төсвийг оновчтой төлөвлөж, хуваарилаагүйгээс хэмнэлт үүссэн байна.**

Аймгийн төсвийн нийт зарлага 2018 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар 46'751,5 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 40713,6 сая төгрөг буюу 87,1 хувийн гүйцэтгэлтэй байна.


			/мян.төг/	
Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	46 751,50	40 713,60	6 037,90	87,09
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	39 243,20	35 910,40	3 332,80	91,51
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30 173,30	27 472,00	2 701,30	91,05
ТАТААС	628,60	625,90	2,70	99,57
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	8 441,40	7 812,50	628,90	92,55
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	6 654,10	4 500,10	2 154,00	67,63
<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЗЭЭЛ</b>	854,20	303,10	551,10	35,48

Үүнээс орон нутгийн төсвийн нийт зарлага 24088,8 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 19463,2 сая төгрөгийг зарцуулан 80,8 хувь, Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад 22647,8 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 21250,5 сая төгрөгийг зарцуулан 93,8 хувийн тус тус гүйцэтгэлтэй байна.




Зарлагын гүйцэтгэлийг графикаар үзүүлбэл:

/График2/



Үүнээс бараа үйлчилгээний зардлыг графикаар харуулбал

/График3/



Аймгийн 2018 оны төсвийн зарлага 9 дүгээр сарын 30-ны байдлаар 6037,9 сая төгрөгийн хэмнэлттэй гарсан нь дараах хүчин зүйлүүдээс шалтгаалсан байна. Үүнд:

**Урсгал зардал болон урсгал шилжүүлгийн хувьд:**

- Төсвийн сар, улирлын зарлагын хуваарийг боловсруулахдаа байгууллагын үйл ажиллагаа, жилийн төлөвлөгөөтэй уялдуулан оновчтой жигд хуваарилаагүйгээс.

**Хөрөнгийн зардлын хувьд:**

- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, сар улирлын хуваарийг оновчтой хуваарилаагүйгээс.
- Хөрөнгө оруулалтын болон хөрөнгө оруулалтын бус, ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх хөтөлбөр арга хэмжээнүүдийн төлөвлөлтийг бодитой төлөвлөөгүйгээс.
- Аймаг Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2-д заасан нөхцөл байдал үүсээгүй байхад тодотгол хийснээс үүдэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ажлын эрхийг Сангийн Яамнаас хаасантай.

**Эргэн төлөгдөх зээлийн хувьд:**

- ЗГ-ын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 1.8 дахь “Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн сонгон шалгаруулалтын товыг сангийн хөрөнгийн эх үүсвэрийн 20-иос доошгүй хувь бүрдсэн тохиолдолд тухайн сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал тогтооно” гэсэн заалтыг баримтлан ажиллаагүйтэй.

**3.2. Төсвийг зарцуулахдаа Төсвийн болон ТБОНӨХБАУХА тухай хуулийн заалтуудыг зөрчсөн байна.**

1.Тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжихгүй, өөрийн чиг үүрэгт хамаарахгүй хөрөнгийг санхүүжүүлсэн байна. Үүнд:

**Аймгийн хөрөнгө оруулалтаар**

- Чойбалсан нисэх онгоцны буудлын хүлээн авах танхимын засварт 19,4 сая төгрөг,

**Сүмдын хөрөнгө оруулалтаар**

- Чойбалсан нисэх онгоцны буудлын хүлээн авах танхимын засварт 8,0 сая төгрөг /Хэрлэн сум/,
- ЗХ-ийн 327 дугаар ангийн хашаанд ЗХУ-ын 4 удаагийн баатар, БНМАУ-ын баатар, ЗХУ-ын маршал Г.К.Жуковын хөшөөг байгуулахад 9,9 сая төгрөг /Хэрлэн сум/,

Энэ нь төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24 дэх заалтад “Хөрөнгө оруулалт” гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг”, 6.6.6-д “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх, мөн Сангийн яамнаас ирүүлсэн “ Орон нутгийн 2018 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах, чиглэл, удирдамж”-ийн 2.26-д “... орон нутагт үүссэн тулгамдсан асуудал, зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах” гэсэн заалтуудтай зөрчилдөж байна.

2. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд хөрөнгө оруулалтын бус шинжтэй ажлуудыг батлуулан зарцуулсан байна. Үүнд:

**Сүмдын хөрөнгө оруулалтаар:**

- ЗДТГ-ын авто машины урсгал засварт 2785,2 мянган төгрөг /Баян-Уул сум/,
- Улзын хөгжил ОНӨҮГ-ын автомашины урсгал засварт 4500,0 мянган төгрөг /Баян-Уул сум/,
- Ахмадын хорооны үйл ажиллагааг дэмжих, урамшуулахад 760,0 мянган төгрөг /Баяндун сум/,
- Багийн туслах ажилтны урамшуулалд 560,0 мянган төгрөг /Баян-Уул сум/,

3. Баяндун сум нь дөнгөж эхлэлийн шатандаа явж байгаа 15,0 сая төгрөгийн өртөгтэй моргийн барилгын ажлын санхүүжилт 14,0 сая төгрөгийн гүйлгээ хийснийг баталгаажуулах шатанд нь буцаалгасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24.4 дэх “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно”, 41.2.6 дахь “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх”, Сангийн Сайдын 2016 оны 415 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 4.20 дахь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсвөөс санхүүжүүлэхийг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байсан.

4. Аймгийн төсвийн хөрөнгөөр 2018 онд хэрэгжүүлэх 280,0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээний ажил дараа онд шилжих нөхцөл байдал үүсээд байна. Үүнд:

**Орон нутгийн хөрөнгө оруулалтаар:**

- Нийтийн орон сууцын барилгын дээврийн засвар 160,0 сая төгрөг,
- Хэрлэн сумын 11 дүгээр багийн байр 90,0 сая төгрөг /өрхийн эмнэлгийн хамт/,

**Орон нутгийн авто замын сангийн хөрөнгөөр:**

- Шүр захын урд уулзварыг өөрчлөн 4 замын уулзвар болгох ажил 30,0 сая төгрөг.

Энэ нь тодотголоор тооцоо судалгаагүй хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн баталсан, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл бүрэн хангагдаагүй, хөрөнгө оруулалтын ажлууд батлагдсан сар хуваарийн дагуу хийгдээгүй, тендерийг оройтуулан зарласан зэргээс шалтгаалсан байна.

5. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон 9,7 сая төгрөг, хандиваар ирсэн 9,4 сая төгрөг, нийт 19,1 сая төгрөгийн 25 хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй байна. Үүнд:

- Ерөнхий боловсролын сургууль 3,5 сая төгрөгийн камер /Цагаан-овоо сум/
- Эрүүл мэндийн төв хандиваар ирсэн 2 ш нэг бүр нь 4,7 сая төгрөгийн орон сууц /Цагаан-овоо сум/
- ЗДТГ нь 6,2 сая төгрөгийн 22 ширхэг тоног төхөөрөмж, тавилга эд хогшил /Баяндун сум/

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, ..., тайлагнах”, 41.2.3 дахь “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэж заасныг зөрчсөн байна.

6. Булган сумын Эрүүл мэндийн төвийн дарга, их эмч нь ажилчдын ажлын үр дүнг дүгнэлгүй 5394,0 мянган төгрөгийн урамшууллыг нийт ажиллагсад олгосон нь Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4-д "үр дүнгийн гэрээний биелэлт, хэрэгжилтийн явц байдалд үндэслэн үр дүнгийн гэрээг дүгнэх эрх бүхий этгээд нь дараах арга хэмжээг авна", 40.4.2 дахь "хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд урамшуулах, хариуцлага тооцох", Улсын Их Хурлын 67 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой Засгийн газраас өгсөн чиглэлийг тус тус зөрчсөн байна.

**IV бүлэг. ТЕЗ-ийн 2018 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилт зорилтот түвшиндээ хүрээгүй байна.**

**4.1. ТЕЗ-ийн төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний чанарын болон тоон үзүүлэлтийг, хууль, журамд заасны дагуу төсөв захирагч бүрээр тодорхойлоогүй байна.**

Төсвийн эрх захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнг хэрэгжүүлэх байгууллага, төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэрийг тодорхой тусган аймгийн ИТХ-аар батлуулаагүй байна.

Энэ нь Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх "Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрт үндэслэн тухайн жилд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн зорилт, арга хэмжээ, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хариуцах байгууллага, төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэрийг тодорхойлсон байна", 18 дугаар зүйлийн 18.1 дэх "Дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичигт төсөв, санхүүгийн тооцоолол, эх үүсвэрийг нарийвчлан тусгасан байна", СС-ын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын 7 дугаар зүйлийн 7.5.6 дахь "аймаг, нийслэлийн Засаг дарга хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг төсвийн захирагч бүрээр гаргаж төсвийн төслийн хавсралт байдлаар боловсруулж, дараах зүйлийг тусгана", мөн тушаалын 3 дахь заалт "орон нутгийн тухайн шатны төсвийн төслийг энэ тушаалын 2 дугаар хавсралтад заасан загвар, маягтын дагуу батлуулахыг аймаг, нийслэл сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус даалгасугай" гэснийг баримтлан ажиллаагүй байна.

**4.2. ТЕЗ-ийн 2018 оны батлагдсан хөтөлбөр арга хэмжээний биелэлт хангалтгүй байна.**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 7 дугаар хуралдааны 13 дугаар тогтоолоор батлагдсан хөрөнгө оруулалтын болон хөрөнгө оруулалтын бус хөтөлбөр, төсөл арга хэмжээний биелэлт 9 дүгээр сарын 30-ны байдлаар нийт 53,7 хувьтай байна.

- Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2018 онд 50 нэр төрлийн 2126,4 сая төгрөгийн ажил хийхээр төлөвлөгдсөнөөс 1008,6 сая төгрөгийн ажил хийгдсэн нь 47,4 хувийн гүйцэтгэлтэй байна.
- Хөрөнгө оруулалтын бус хөтөлбөр арга хэмжээнд 2018 онд 58 нэр төрлийн 1188,1 сая төгрөгийн ажил хийхээр төлөвлөгдсөнөөс 712,9 сая төгрөгийн ТАХ хэрэгжин 60,0 хувийн гүйцэтгэлтэй байна.
- Авто замын сангийн хөрөнгөөр 2018 онд 346,1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 8 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 185,3 сая төгрөгийн ажил

хийгдэн 53,5 хувийн гүйцэтгэлтэй байна.

- Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2631,8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 1416,3 сая төгрөгийн буюу 53,8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс 14 сумдын, төрийн болон орон нутгийн өмчит газруудын 2018 оны зорилтот жилийн хэрэгжилтийн явцад Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт үнэлгээ хийсэн байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс 2018 оны хагас жилийн үр дүнгийн гэрээний биелэлтэд хийсэн үнэлгээгээр 5 сум, 23 байгууллага хугацаандаа, 7 сум хугацаа хоцроон, 2 сум, 9 байгууллага биелэлтээ гарган ирүүлээгүй байна.

Уг үнэлгээгээр 4 сум 21 байгууллага 70 хувь, 7 сум, 2 байгууллага 40 хувийн биелэлттэйгээр дүгнэгдэж, 1 сум хангалтгүй гэж үнэлэгдсэн байна.

Энэ нь Төсвийн захирагч нарын хууль тогтоомжийн дагуу хүлээсэн үүргийн биелэлт хангалтгүй, хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх дүн зорилтот түвшиндээ хүрээгүй байгааг харуулж байна.

#### **4.3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналтын ажлын үр нөлөө хангалтгүй байна.**

ТЕЗ-ийн дотоод хяналт нь Төсвийн тухай хуулийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.”, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 5.2.4-т “төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашгийн байдалд хяналт тавих”, 8.5-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагчийн болон бусад төсвийн захирагчдын дотоод аудитын үйл ажиллагаанд дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын дагуу чанарын хяналтын үнэлгээг 2 жилд 1 удаа хийнэ” гэсэн заалтуудаар тус тус зохицуулагдаж байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, Төсвийн ерөнхийлөн захирагчийг эрсдэлийг удирдлагаар хангах чиг үүргийнхээ дагуу 2018 оны төсвийн төсөлд зөвлөмж өгч ажилласан байна. Хяналт шалгалтаар гарсан алдаа зөрчил давтагдан гарсаар байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2018 оны хэрэгжилтэд 11 дүгээр сард хийхээр төлөвлөж ТЕЗ-аар батлуулсан байна.


## **ДҮГНЭЛТ**

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Төсвийн тухай хуульд заасны дагуу жилийн төсвийн хязгаарын саналыг Сангийн Яаманд хүргүүлээгүй байна.

2. Төсвийн суурь зарлага нь Сангийн Яамны тогтоосон хязгаараас 9,4 тэрбум төгрөгөөр хэтэрсэн байна.
3. Төсвийн тухай хуулиар заагаагүй нөхцөлд аймгийн төсөвт тодотгол хийсэн байна.
4. Аймгийн 2018 оны төсвийн орлогын эх үүсвэрийг үндэслэлтэй төлөвлөөгүй байна.
5. Төсвийн тухай хуульд заасан зарчим шаардлагад нийцэхгүй хөтөлбөр, төсөл арга хэмжээг зарцуулахаар төлөвлөн баталсан байна.
6. Аймгийн 2018 оны төсвийг алдагдалгүй баталсан байна.
7. Аймгийн төсвийн 2018 оны нийт орлогын төлөвлөгөөг бүрэн хэрэгжинэ гэж тооцох боломжгүй байна.
8. ОНӨААТҮГ-уудад татаасыг бууруулах, орлого нэмэгдүүлэх боломж байна.
9. ТЕЗ-ийн төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний чанарын болон тоон үзүүлэлтийг, хууль, журамд заасны дагуу төсөв захирагч бүрээр тодорхойлоогүй байна.
10. ТЕЗ-ийн 2018 оны батлагдсан хөтөлбөр арга хэмжээний биелэлт хангалтгүй байна.
11. Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналтын ажлын үр нөлөө хангалтгүй байна.

Аудитаар нийт 66490,5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлэн 6,7 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоон, зөрчил арилгуулах 2 албан шаардлага, 13 зөвлөмж өгч ажиллалаа.



## **ЗӨВЛӨМЖ**

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

### **Аймгийн ИТХ-д:**

1. Монгол Улсын Засаг Захиргаа Нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22.1.9, 25.4-д заасныг мөрдөн ажиллах, зөвлөмж өгөх.

### **Аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн-д**

1. Төсвийн тухай хуульд заасны дагуу жилийн төсвийн хязгаарын саналыг Сангийн Яаманд хүргүүлж байх.
2. Сангийн Яамны баталсан суурь зарлагын хязгаарт багтаан төлөвлөж байх.
3. Төсвийн тухай хуулийн 34.2 дахь заалтыг мөрдөн төсөвт тодотгол хийж байх.
4. Төсвийн орлогыг тооцоо судалгаатай, үндэслэлтэйгээр төлөвлөж байх.
5. Хууль, журамд нийцээгүй төсөл хөтөлбөрт зориулан хөрөнгө оруулалтын хийхээр төлөвлөхгүй байх.
6. Зарим ОНӨААТҮГ-дад аймгаас өгөх татаасыг бууруулж, орлого нэмэгдүүлэх, үр дүнтэй ажлыг зохион байгуулж ажиллуулах.
7. ТЕЗ-ийн хэрэгжүүлж буй ТАХ-ний чанарын болон тоон үзүүлэлтийг СС-ын 2012 оны 244 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтад заасан загвар, маягтын дагуу боловсруулан ИТХ-аар батлуулах.
8. Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь ТЕЗ-ийн Хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэд тавих дотоод хяналтын үр нөлөөг сайжруулахад анхаарах.


### **Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Н.Базаррагчаа-д**

1. Сар, улирлын зарлагын хуваарийг үйл ажиллагаатай уялдуулан оновчтой боловсруулах, төсвийн төлөвлөлтийг сайжруулах.
2. “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын хэрэгжилтийг хангуулах.
3. Төсвийн болон ТБОНӨХБАҮХА тухай хууль түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан журам зааврыг мөрдөж ажиллах.

### **Аймгийн татварын хэлтсийн дарга С.Бямбарагчаа-д:**

1. Орон нутгийн 2018 оны төсвийн орлогыг бодитой төлөвлөх.

Аудитаар тавигдсан зөвлөмжийн биелэлтийг хангуулж 2019 оны 12 дугаар сарын 05-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.



Дарга Бөгөөд Тэргүүлэх аудиторын  
2018 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн  
06 дугаар тоот тушаалын хавсралт 1

**Төлбөрийн актыг жагсаалт**

№	Байгууллагын нэр	Гүйцэтгэлийн аудитын дугаар	Төлбөрийн актыг утга	Мөнгөн дүн
1	2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц	САГ-2018-02-СА	Хөрөнө оруулалтын төсөл арга хэмжээний урамшуулалд 1320,0 мянган төгрөг зарцуулсан, өмнөхдөө үр дүнгийн гарамгай биелэлтийг дүнгээгүй 5394,0 мянган төгрөгийн урамшуулалыг тус тус олгосон.	6,714,000.00
2	Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн	САГ-2018-03-СА	Эзлэлийн амралтын цагийг илүү дутуу тооцон 3538,6 мянган төгрөг, үр дүнгийн урамшуулал давхардуулан 293,6 мянган төгрөгийг тус тус олгосон.	3,732,284.00
<b>Нийт дүн</b>				<b>10,446,284.00</b>

Дарга Бөгөөд Тэргүүлэх аудиторын  
2018 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн  
06 дугаар тоот тушаалын хавсралт 2

**Албан шаардлагын жагсаалт**

№	Байгууллагын нэр	Гүйцэтгэлийн аудитын дугаар	Албан шаардлагын утга	Мөнгөн дүн
1	АЗДТГ	САГ-2018-02-СА	Төсвийн тухай хууль мөрдөж ажиллах	1,513,200,000.00
2	АЗДТГ	САГ-2018-02-СА	Төсвийн эрх захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнг хэрэгжүүлэх байгууллага, төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэрийг баталгааны замаар мангын дагуу боловсруулан батлуулах	85,038,341,100.00
3	АЗДТГ	САГ-2018-03-СА	Зөрчил арилгуулах тухай	696,000,000.00
<b>Нийт дүн</b>				<b>67,245,541,100.00</b>



